

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 19 2023 оны 5-р сар

ГОВЬ, ХЭЭРИЙН ЭКО БҮСЭД БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХЭД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛҮҮД ■ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУВЬД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Салхитын уурхайн Хаалтын менежментийн төлөвлөгөөний (ХМТ) үндсэн зорилго нь “Нөхөн сэргээсэн талбайг нутгийн иргэдийн уламжлалт газар ашиглалтад нийцүүлэн, байгалийн унаган төрхөд ойртуулан хаах” юм. Тус уурхай нь Дундговь аймгийн талархаг нутагт зүүн говь, хээрийн бүсийн зааг дээр оршдог.

Уг экологийн бүсийн хувьд эх газрын эрс тэс, уур амьсгалтай, температурын хэлбэлзэл өндөр, хүйтэн өвөл, халуун, богино зунтай бүс нутагт хамаардаг. Говь цөл, хээрийн бүсэд салхины элэгдэл эвдрэл ихээр үүсдэг онцлогтой бөгөөд сүүлийн 20 жилд хүчтэй салхи, шороон шуурганы тоо харьцангуй ихэссэн байна (Бадамсүрэн, 2022). Уурхай орчимд жилийн дундаж агаарын температур бага зэрэг нэмэгдсэн нь зуны аагим халуун улирлын өдрүүдийн тоо ихэссэнтэй холбоотой. Хур тунадасны хэмжээг авч үзвэл зуны хур тунадасны хэмжээ мэдэгдэхүйц (ойролцоогоор 1 мм/жил) буурсан бөгөөд энэ нь жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ багасахад нөлөөлж байна.

Салхитын уурхай орчимд карбонатын агууламж багатай, үржил шим муутай хөрс зонхилдог. Салхины элэгдэл нь хөрсний нарийн ширхэгт тоосонцрыг хийсгэж, том ширхэгтэй элс, жижиг хайрга үлдээдэг бөгөөд энэ нь ургамал ургахад хүндрэл учруулдаг. Уурхайн ашиглалт гэх мэт байгалийн ургамал, хөрсийг хуулж авдаг газар ашиглалтын дараа уг эко бүс нутгийг нөхөн сэргээхэд ихээхэн бэрхшээлтэй байдаг.

Энэхүү нийтлэлд уурхайн нөхөн сэргээлтийн үр дүнд нөлөөлөх аливаа эрсдэлийг бууруулах, өөрийгөө тэтгэх экосистемийн тогтолцоо бүрдүүлэх зорилгоор Салхитын уурхайн ХМТ-нд тусгагдсан биологийн нөхөн сэргээлтийн арга техник, судалгааны ажил, туршилтуудыг танилцуулж байна.

■ БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ТЕХНИК, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хөрс хуулалт, шимт хөрсний овоолго хийх

Говийн бүсэд үржил шимт хөрс хомсдолтой байдгаас үүдэн нөхөн сэргээлтэд ашиглах шимт хөрсийг зохих шаардлагын дагуу хуулж, шимт хөрсний овоолго үүсгэж хадгалах нь чухал. Ийн хадгалсан шимт хөрсийг аливаа элэгдлээс хамгаалахын тулд овоолго дээр нутгийн өвс, буурцагт ургамлыг тариалах стратегийг хэрэгжүүлдэг. Мөн салхины нөлөөг багасгахын тулд овоолгын байршлыг салхины чиглэлээс үүдэн сайтар төлөвлөх нь шимт хөрсний элэгдлийг бууруулах ач холбогдолтой.

Хөрс хучилт, өөрчлөлт

Уурхайн үйл ажиллагаанд өртөж, эвдэрсэн талбайг шимт хөрсөөр хучих нь газар хэлбэршүүлэлт (техникийн нөхөн сэргээлт)-ийн ажлын дараа, биологийн нөхөн сэргээлт хийх нөхцөлийг бүрдүүлж, талбайг бэлдэхэд чиглэнэ. Салхитын уурхай орчимд байгалийн хөрсний зузаан нь ургах ургамлын төрлөөс хамаарч 15 см-ээс 30 см-ийн хооронд хэлбэлздэг. Шимт хөрс хангалтгүй байгаа газруудад ургамлыг ургах орчин, шим тэжээлээр хангахын тулд нэмэлт органик материал (мал, амьтны ялгадас) оруулна.


Хаалтын газар хэлбэршүүлэлт хийгдсэн талбайд хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх эрсдэлтэй бөгөөд нөхөн сэргээсэн талбайд хяналт мониторинг тавих, арчилгаа тордлогоо хийх нь чухал. Хөрсний элэгдлийг сааруулах аргачлалыг Салхитын уурхайн ХМТ-д дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Ургамалжуулалт

Хаалтын нөхөн сэргээлт хийсэн талбай нь цаашид бэлчээрийн зорилгоор ашиглагдана. Иймд олон зүйлийн нутгийн ургамлыг тарих нь малын бэлчээрийг дэмжих, хөрсний элэгдлийг сааруулах, зэрлэг амьтдын амьдрах орчныг бүрдүүлэх, биологийн олон янз байдлыг бий болгох зэрэг олон талын ач холбогдолтой. Ганд тэсвэртэй, хүчирхэг үндэс бүхий нутгийн ургамлыг тарих нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон нөхөн сэргээлтийн үр дүнг бий болгоно.

Ургамалжуулалт хийх талбайд (тухайлбал: налуу, талархаг, чийглэг) өөр өөр бичил орчин байдаг тул ургамлын бүлгэмдлийг сонгохдоо хэлбэршүүлэлт, нөхөн сэргээлтийн нэгж талбарт тохируулна. Дараах төрлийн ургамлын зүйлийн бүрдлүүд нь нөхөн сэргээлтэд ашиглагдана:

Ургамлын төрөл зүйлийн нэр	Газар хэлбэршүүлэлт хийсэн нэгж талбар
Хялгана-таана-монгол өвс-харганат тариалан байгалийн хаалт үүсгэх	Ил уурхайн үхашийн ирмэг
Олон наст үетэн ургамлын хольц	Ил уурхай, уурхайн зам, ажилчдын байр орчмын налуу гадаргуу
Зэгс шагшуурга	Ил уурхайн нүүрын эрэг
Харгана, хормойгоор нь дэрс	Хаягдал чулуулгийн овоолго
Үетэн, буурцагтан, таана, харгана	Баяжуулах үйлдвэр, шатахууны агуулах,
Үетэн, буурцагтан, таана, агь боролзой шаваг, харгана	Тэсрэх материалын талбай



Зураг 1. Төслийн байгаль орчны зөвлөх баг Салхитын уурхай дээр хээрийн судалгаа хийж буй нь

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МОНИТОРИНГ, УРГАМАЛЖУУЛАЛТЫН СУДАЛГАА, ДАСАН ЗОХИЦОХ МЕНЕЖМЕНТ

Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн гүйцэтгэлд (хөрс, ургамал) хяналт мониторинг хийснээр тухайн газар нутагт байгалийн экосистемийн тогтолцоо бий болсон эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Салхитын уурхайн ХМТ-ний хяналт, мониторингийн хүрээнд хөрсний үржил шим, ургамлын ургах явц, үр дүнг хянах зорилготой шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон болно.

Салхитын уурхайд нөхөн сэргээлтийн зориулалтаар тарих ургамлын туршилтын судалгааны ажил хийгдэх бөгөөд энэхүү судалгаа нь нөхөн сэргээлтийн мониторингийн хөтөлбөрөөс тусдаа ойлголт юм. Судалгааны хөтөлбөрийн гол зорилго нь уурхайн талбайд үүсэж болзошгүй эрсдэлийг хянаж бууруулах хариу арга хэмжээнүүдийг тодорхойлох, нөхөн сэргээлтийг ажлыг хийхэд хамгийн үр дүнтэй арга, аргачлалыг судалж тогтоох юм. Судалгааны ажлын дараах 2 стратегийг санал болгож байна.

Туршилтын төрөл	Тайлбар
Үр түүж цуглуулах, тарьц суулгац бэлтгэх	Үр түүж цуглуулах, суулгац тарих технологи, аргачлалын талаар зохих судалгаа хийх нь нутгийн ургамлын үрийг түүж цуглуулах, тарималжуулах талаар илүү сайн ойлголт өгнө. Судалгаа нь нөхөн сэргээлтэд ашиглахад тохиромжтой ургамлын үрийг цуглуулах, тэдгээр ургамлын үр соёолох, ургах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал юм.
Үр тарих норм.	Уурхайн нэг га талбайд тарих үрийн норм MNS 5918:2008 стандартад 10-20 кг гэж заасан байдаг. Гэвч үр түүж цуглуулах, хадгалах, үрслүүлэхтэй холбоотой гарах зардлыг тооцвол уг норм хэт өндөр юм. Хаалтын нөхөн сэргээлтийн ургамлын төрөл зүйлийн үрийн нэг га талбайд тарих хэмжээ, үрийн хольц, харьцааг туршилт, судалгаагаар тодорхойлох шаардлагатай.

Мониторингийн хөтөлбөр, судалгааны ажлын үр дүнд үндэслэн биологийн нөхөн сэргээлтийн арга техникийг өөрчилж болно, жишээлбэл, хөрс бэлтгэх арга техникийг тодорхойлох, тарих нягтралыг өөрчлөх эсвэл өөр технологи ашиглах гэх мэт. Дасан зохицох менежментийг төлөвлөх нь уур амьсгалын өөрчлөлтийн тодорхой бус байдлын үед авах чухал арга хэмжээний нэг юм.

Ашигласан материал: Э.Бадамсүрэн (2022). [Дундговь аймагт сүүлийн 20 жилд явагдсан уур амьсгалын өөрчлөлт]

НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Уурхайн хаалтын нийгэм, эдийн засгийн шилжилт нь уул уурхайн компаниудын идэвхтэй оролцоо, төрийн байгууллагуудын дэмжлэг, манлайлал, оролцогч талуудын нягт хамтын ажиллагааг шаарддаг маш чухал үйл ажиллагаа юм.

Эрдэнэс Силвер Ресурс ХХК нь төрийн өмчит уул уурхайн компанийн хувьд хариуцлагатай уул уурхайн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах, түүчээлэх зорилготой. Тус компани нь төрийн өмчит тогтолцоо бүхий эрх мэдлийн хувьд хязгаарлагдмал хэдий ч бүс нутгийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Эрдэнэс Силвер Ресурс ХХК нь уурхайн хаалтын үеийн нутгийн иргэд, компанийн ажилчид, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд нийгэм, эдийн засгийн шилжилтийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. Энэхүү шилжилтийн үеийн төлөвлөгөө, арга хэмжээг хэрэгжүүлснээр компани, иргэдийн хоорондын итгэлцлийг нэмэгдүүлэх, хариуцлагыг баталгаажуулах, эмэгтэйчүүдийн дуу хоолой, үзэл бодлыг сонсох зэрэг олон нийтийн санал хүсэлт дээр үндэслэн дасан зохицох менежментийг бий болгоход чиглэж байна.

Төрийн байгууллагуудын зүгээс уул уурхайн компаниудын хаалтын үйл ажиллагааны явцад байгаль орчин, нийгмийн стандартыг мөрдүүлэхэд шаардлагатай зохицуулалт, бодлого, хөшүүргийг бий болгох нь нэн чухал.



Зураг 2. Уурхайн хаалтын төлөвлөгөөний төслийн талаар иргэдэд мэдээлэл өгөх, санал авах зорилготой зохион байгуулсан "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийн үеэр Нийгэм, Эдийн засгийн зөвлөх баг нөлөөлөлд өртсөн нутгийн малчид, иргэдэд мэдээлэл өгч, харилцан ярилцаж буй нь.

Тодруулбал, уурхайн хаалтын нөлөөлөлд өртсөн иргэдийн нийгэм, эдийн засгийн шилжилтийг хөнгөвчлөхөд аймаг, сумын түвшний нутгийн захиргааны байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагын хувьд уурхайн хаалтын төлөвлөгөөний үйл явцад манлайлан оролцож, нутгийн иргэдийн оролцоотойгоор хаалтын үеийн эдийн засгийн боломжуудыг тодорхойлох, нэмэгдүүлэхэд анхаарч байна. Үүнд аялал жуулчлал, хөдөө аж ахуйн эдийн засгийн боломжууд зэрэг бүс нутгийн бодлогод нийцсэн, тухайн газрын нөөц, давуу талд тулгуурласан тогтвортой санаачлагууд байна.

Гурвансайхан сумын нутгийн захиргааны байгууллага нь Салхитын мөнгөний уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд иргэдэд түшиглэсэн хяналтын механизмыг бий болгож байна. Энэхүү оролцоо нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад хувь нэмэр оруулахын зэрэгцээ орон нутгийн засаг захиргаа болон иргэдийн хариуцлагын ойлголтыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлснээр Эрдэнэс Силвер Ресурс ХХК болон бүх түвшний төрийн байгууллагууд уурхайн хаалт болон шилжилтийн үйл явцын ерөнхий үр нөлөөг сайжруулж, нөлөөлөлд өртсөн орон нутаг, байгаль орчинд иж бүрэн, хүртээмжтэй үр дүнг бий болгох юм.

ХОЛБОО БАРИХ

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн захирал
Р.Алтангэрэлтэй имэйл хаягаар холбогдоно уу.
r.altangerel@merit.mn

Бид та бүхэнд Салхитын уурхайн хаалтын мэдээ мэдээллийг аль болох сонирхолтой байдлаар хүргэхийг зорьдог билээ. Төслийн оролцогч талуудын санал, сэтгэгдлийг сонсож, бэлтгэж буй мэдээ мэдээллийг уншигчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх нь чухал юм. Тиймээс та бүхэн төслийн сар тутмын мэдээтэй холбоотой санал сэтгэгдлээ бидэнтэй хуваалцана уу.